

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо : 2021-04-26

Тендер шалгаруулалтын нэр: **Тэжээлийн деаэратор №4-ийн шинэчлэх ажил**
Тендер шалгаруулалтын дугаар: **ДЦС2/202103008**

ДЦС-2 ТӨХК эрх бүхий тендерт оролцогчдоос “**Тэжээлийн деаэратор №4-ийн шинэчлэх ажил**” –ыг гүйцэтгэх тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

Тендерийн баримт бичгийг (хүсвэл нэмэлт хувийг) бичгээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдэл бүрийг нь **50,000** төгрөгөөр худалдан авч болно. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн **30** хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.

Үүнд:

Борлуулалтын хэмжээ: **Сүүлийн 1 жилийн борлуулалтын орлого санал болгож буй үнийн дүнгээс багагүй байна.**

Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: **санал болгож үнийн дүнгээс багагүй байна.**

Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: **1 жил**

Сүүлийн гурван жилд хэрэгжүүлсэн ижил төстэй ажлын өртөг:

Төсөвт өртгийн 50 хувиас доошгүй байх

Тусгай зөвшөөрөл шаардлагатай бол тусгай зөвшөөрөл ирүүлэх эсэх: **шаардлагатай**

Тендерийн хамт **4,400,000** төгрөгийн дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.

Тендерийг **2021 оны 05 сарын 28**-ны өдрийн **10 цаг 00 минут**–аас өмнө цахимаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг **2021 оны 05 сарын 28 ны өдрийн, 10 цаг 30 минут**-т нээнэ.

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхгүй
Дотоодын давуу эрх тооцох эсэх. Тооцохгүй

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 20-р хороо, ДЦС-2 ТӨХК өөрийн байр

109 тоот

Утас 70172157, /факс 70172177